

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2023





## АГУУЛГА

■ БИДНИЙ ТУХАЙ	6
■ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	17
■ ХАМТЫН АЖИЛЛАГАА	19
■ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	24
■ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ	35
■ ТАЙЛАГНАЛ	42

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бүхэнд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэн, 2023 оны “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН”-гаа танилцуулж байна.

Бид харилцагч, бизнесийн хамтрагч Та бүхний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй,

нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжиж бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхийн төлөө онцгойлон анхаарч, хичээнгүйлэн ажиллаж байна. Банкны нийт зээлийн багц 2.4 их наяд төгрөг, нийт депозит 4.0 их наяд төгрөг, нийт активыг 5.4 их наяд төгрөгт тус тус хүргэж, татварын дараах цэвэр ашгийн хэмжээ 94.8 тэрбум төгрөгт хүрснээс гадна 2022 оны татварын дараах цэвэр ашгийн 50 хувь буюу 48.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тайлант онд хувьцаа эзэмшигчдэдээ хуваариллаа.

Төрийн банк 2023 онд НҮБ-ын Даян дэлхийн гэрээ болон Нидерландын нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэлд гишүүн байгууллагаар элссэн. Бид санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын ил тод байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын аргачлалын дагуу тооцож, тайлагнах, уур амьсгалтай холбоотой шилжилтийн эрсдэлийг удирдах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх тухай Парисын

хэлэлцээртэй үйл ажиллагаагаа уялдуулахаар зорин ажиллаж байна.

Төрийн банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн, Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа нь манай банкны үйл ажиллагаа жигд өсөж буйг харуулахын зэрэгцээ хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бидний нягт хамтын ажиллагааны үр дүн гэж дүгнэж байна. Энэ ташрамд биднийг тууштай дэмжиж, итгэл үзүүлж байдагт та бүхэнд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлэхэд таатай байна. Улс орны хөгжлийн үндсэн суурь, тулгуурын нэг болсон банктай ажил, амьдралын зам мөрөө холбосон хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бидний ашиг, орлого улам бүр арвижиж, ажил үйлс өргөжин хөгжихийн ерөөл дэвшүүлье.

Хүндэтгэсэн:

**Б.ТЭЛМҮҮН**

**ТУЗ-ИЙН ДАРГА,  
Сангийн яамны Татварын  
бодлогын газрын дарга**

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Төрийн банкны эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, бизнесийн түншүүд Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Банк бол итгэлцэл дээр тогтдог бизнес. Ил тод, нээлттэй байдал бол хамгийн чухал зарчим нь. Тиймээс ч Төрийн банкны хамт олон бид 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлангаа танилцуулж буйдаа туйлын баяртай байна. Банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харилцагчдынхаа эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2009 онд байгуулагдсан манай банк өдгөө эх орныхоо өнцөг булан бүрт байрлах 500 орчим салбар нэгж, 4000 орчим ажилтнуудаараа дамжуулж 2.3 сая харилцагчдадаа банкны бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна.

Төрийн банк нь Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 2022 онд арилжааны банкуудаас анхлан нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт

амжилттай шилжиж байв. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын шалгуур үзүүлэлтийг хангаж, ТОП-20 индексийн шинэчилсэн жагсаалтад 2023 онд дахин багтсанаар амжилтаа бататгалаа. “Төрийн банк” ХК харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжиж бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэгч иргэддээ зориулан эрүүл мэндийн үйлчилгээний хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой олон улсын “Эрүүл иргэн” виза дебит картыг зах зээлд шинээр нэвтрүүлснээс гадна орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хялбар, энгийн шийдэл бүхий Гялсбанк үйлчилгээний шинэчлэгдсэн 3.0 хувилбарыг харилцагчдадаа санал болгоод байна. Бид банкны “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-оо НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах, урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог хангах, 2030 онд Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнийг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зэрэг зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Төрийн банк нь Тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн туршлагыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд оролцогч байгууллагаар 2023 оны тавдугаар сард нэгдэн орлоо. НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд гишүүнээр элссэнээр бизнесийн үйл ажиллагаанд аливаа шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хүчин зүйлсийг тусгаж, тогтвортой хөгжлийн зорилтод

нийцсэн төслүүдийг дэмжсэнээр илүү тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийг хөгжүүлэхийн төлөө ажиллах болно. Түүнчлэн банкны ажилтан, хувьцаа эзэмшигч, харилцагч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч түнш болон бусад оролцогч талуудын итгэлцлийг нэмэгдүүлэн харилцаа холбогч өргөн хүрээнд бэхжүүлэхээр зорьж байна. Төрийн банк цар тахлын дараагийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн 35 төсөл, Хөдөөгийн сэргэлт, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд амжилттай оролцон төрийн санхүүгийн зуучлагч болон ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Төрийн банк өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар нийт активаа 28.9 хувиар өсгөж 5.4 их наяд төгрөгт, нийт зээлийн бацгаа 2.4 их наяд төгрөгт хүргэж, өөрийн хөрөнгөө 15.9 хувиар өсгөн 575.3 тэрбум төгрөгт хүргэжээ. Мөн энэ хугацаанд банкны ашиг 94.8 тэрбум төгрөгт хүрч, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ итгэл төгс биелүүллээ. Энэ бол Төрийн банкны нийт ажилтан, албан хаагчид, харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч байгууллагуудын хамтдаа хүрсэн амжилт гэдгийг цохон тэмдэглэе. Та бүхэндээ амжилт хүсье

Хүндэтгэсэн:

**Ө.ГАНТӨР**

ТӨРИЙН БАНКНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

## БИДНИЙ ТУХАЙ



“Төрийн банк” ХК нь Монгол Улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн Монголбанкнаас 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр олгогдсон “26” дугаар бүхий БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭТЭЙ болно.

“Төрийн банк” ХК банкны системд нөлөө бүхий банкуудаа манлайлан хувьцаагаа “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан олон нийтэд нийт хувьцааныхаа 5.71 хувийг санал болгож, 7421 хувьцаа эзэмшигчээс 25.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээр хөрөнгийн зах зээлийн түүхэнд нэгэн шинэ хуудас нээн, нээлттэй хувьцаат компани болсон юм.

“Төрийн банк” ХК нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн банк, санхүүгийн цогц үйлчилгээг орон даяар саадгүй хүргэх, бүх талын хамтын ажиллагааг дээдлэх, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн олон талт хэрэгцээг нь хангах зорилгоор орон даяар 500 орчим салбар нэгж, 350 АТМ, картаар үйлчлэгч 8698 байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Төрийн банк” ХК нь 5.4 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангадаг. Төрийн банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монгол Улсын банкны салбарын ТОП 5 банкны нэгээр 2023 онд дахин шалгарч, амжилтаа баталгаажууллаа.

## АЛСЫН ХАРАА

Дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.

## ҮНЭТ ЗҮЙЛС



ИТГЭЛЦЭЛ:

Итгэл, Сэтгэл,  
Хүндлэл



ХАРИУЦЛАГА:

Сахилга бат,  
Сайн үр дүн



УР ЧАДВАР:

Хүний хөгжил,  
Хөгжлийн  
түлхүүр



ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ

Шилэн банк

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь төрийн өмчит “Төрийн банк”-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан “Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсанаас хойш өдгөө 14 дэх жилдээ амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газар 2021 оны наймдугаар сарын 25-нд Төрийн банкийг “Дундаж давхаргыг дэмжигч банк” болгохоор шийдвэрлэсний дагуу орон даяар 500 орчим салбар нэгжээр дамжуулан, 2,3 сая харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх, дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк болох алсын хараатай ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2021 оны нэгдүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Төрийн банк” ХК системийн нөлөө бүхий банкуудаа түүчээлж нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-нд үнэт цаасаа бүртгүүлэн, нийт хувьцааныхаа 5.71 хувийг олон нийтэд санал болгосноор 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.



## ■ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 2023 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 14 удаа хуралдан, 57 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 20 шийдвэр, 107 тогтоол гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Түүнчлэн, 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөл Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр хуралдуулж “Төрийн банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Хувьцаа нэмж гаргах тухай, Хяналтын зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах тухай асуудлыг хэлэлцэн, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны нэгдүгээр сарын 25-нд эчнээ санал хураалтаар явуулж, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр 2023 оны арванхоёрдугаар сарын 01-ний өдөр шийдвэрлэсэн байна.



## ■ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл дэргэдээ Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой ажиллах ба шаардлагатай нөхцөлд цаг үеийн шинжтэй болон бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж ажиллахаар Хороодын үйл ажиллагааны журамд тусгасан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн даргалдаг. Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор хороодын бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн баталлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журамд Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлагуудыг тусган шинэчлэн баталсан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, “Төрийн банк” ХК-ийн дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.



## Аудитын хороо

Аудитын хороо нь банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплаенсийн хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангах чиглэлээр ажиллаж байна.

Аудитын хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2023 онд нийт 14 удаа хуралдан, 42 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 38 шийдвэр гаргаж, 22 үүрэг даалгавар өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

## Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны үйл ажиллагааны чиглэл бүрд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2023 онд нийт 9 удаа хуралдахдаа 28 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 25 шийдвэр гаргаж, 36 үүрэг даалгавар өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

## Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг.

Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал улирал бүр зохион байгуулагдаж, 2023 онд бие даан 3 удаа хуралдахдаа 5 асуудал, Цалин урамшууллын хороотой хамтран 3 удаа хуралдахдаа 4 асуудал хэлэлцсэн буюу нийт 6 удаагийн хурлаар 9 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

## Цалин урамшууллын хороо


Цалин урамшууллын хороо нь Банкны алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлийг хангасан, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, банкны ашиг болон ажлын гүйцэтгэлд суурилсан ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилладаг.

Цалин урамшууллын хорооны хурлыг улирал бүр зохион байгуулж, 2023 онд 4 удаагийн хурлаар 5 асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ.

## БАНКНЫ БҮТЭЦ



# ТҮҮХЭН ТОВЧОО





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН

# ЗӨРИЛГӨ

**1** ядуурлыг устгах

**2** өлсгөлөнг зогсоох

**3** эрүүл мэндийг дэмжих

**4** чанартай боловсролыг дэмжих

**5** жендерийн эрх тэгш байдлыг хангах

**6** баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах

**7** сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх

**8** зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих

**9** инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх

**10** тэгш бус байдлыг бууруулах

**11** ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих

**12** хариуцлагатай хэрэглээг дэмжих

**13** уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах

**14** далай тэнгисийн нөөцийг хамгаалах

**15** хуурай газрын эко системийг хамгаалах

**16** энхтайван, шударга ёсыг цогцлоох

**17** хөгжлийн төлвөх туншлэлийг бэхжүүлэх

## ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

 **2,3 САЯ**  
Нийт харилцагч

 **350**  
АТМ

**500**  
гаруй  
салбар 

 **3,400**  
гаруй  
ажилтан


/батлагдсан орон тоонд ажиллаж байгаа/


Төв > **19%**

УБ > **21%**

ОН > **60%**

**Цахим  
болон бусад  
үйлчилгээ**

 Гялсбанк  
харилцагч **675+**  
мянга

**8,690+**  
КУБ 

 **90**  
Киоск

**1,800**   
Ухаалаг ПОС

 **119+**  
мянга  
Иж бүрэн даатгал



## ОНЦЛОХ АЖИЛ



Банкны ялгаруулсан хүлэмжийн хийг тооцох зорилгоор “Обзерв консалтинг” зөвлөх үйлчилгээний байгууллагаас сургалт, зөвлөгөө авч анх удаа Хамрах хүрээ 1 болон 2-ын хүлэмжийн хийг тооцлоо.



Гялсбанкны 3.0 хувилбар шинэчлэгдэж, 4 төрлийн цахим зээлийг 100 хувь онлайнаар авч, виртуал картаа цахимаар нээж төлбөр тооцоонд ашиглахад хялбар болголоо.



Тогтвортой хөгжлийн стратеги, бодлого, үйл ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх зорилгоор Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос зөвлөх үйлчилгээ авлаа.



Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ аяныг 6 дахь жилдээ зохион байгуулж, Улаанбаатар хотын есөн дүүрэг, 21 аймаг, 330 сумын гол горхи, нуур цөөрмийн эрэг, сав газрын нийт 7400 гаруй га талбайгаас 800 тонн хог хаягдал цуглуулж, төвлөрсөн хогийн цэгт хүргүүлээ.



Дундаж давхаргыг дэмжигч банк зорилтын хүрээнд Инкубатор төвийн харилцагч нийт 18 мянга гаруй бизнес эрхлэгч, 130 мянга гаруй оюутан, сурагчид санхүүгийн боловсрол олгосон.

ИНКУБАТОР  
ТӨВ



“ABILITY EXPO 2023” арга хэмжээтэй Төрийн банк хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд эергээр сурталчлан таниулж, тэдний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, санхүүгийн боловсрол олгон, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг хүргэв.









# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

---


## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

■ Төрийн банкны байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого нь олон улсын болон Монгол Улсын Тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх бодлогын бичиг баримтуудтай уялддаг бөгөөд банкнийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, аливаа сөрөг нөлөөллийг бууруулсан үйл ажиллагааг дэмжиж, зохистой засаглалын тогтолцоог ханган, тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнийг 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувьд хүргэж ажиллах зорилтыг дэвшүүлээд байна.


■ Бид санхүүжилтийн хөшүүргийг ашиглах замаар Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцийн Парисын хэлэлцээрийн дагуу хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицох үндэсний зорилтод хувь нэмрээ оруулах юм.

■ Хүлэмжийн хийг бууруулах зорилгын хүрээнд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй технологийг дэмжих, хөдөө аж ахуйн салбарт малын чанар, ашиг шимийг сайжруулахад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ.

■ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтын хүрээнд ус хэмнэх, саарал усыг ашиглах, химийн бодисын хэрэглээ, хатуу хог хаягдал, эрчим хүчний хэрэглээг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.



Бид 2023 онд тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ, техникийн туслалцаа авах, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, ногоон болон тогтвортой хөгжлийн таксономид нийцүүлэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, нөхцөл шаардлагыг харилцагчийн хэрэгцээнд нийцүүлэхийн зэрэгцээ банкны хүлэмжийн хийн ялгарлыг тооцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.





# **ХАМТЫН АЖИЛЛАГАА, АМЛАЛТУУД**

---

## ХАМТЫН АЖИЛЛАГАА, АМЛАЛТУУД

НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд оролцогчоор нэгдэж, бизнесийн аливаа шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хүчин зүйлсийг тусгаж, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн төслүүдийг дэмжсэнээр илүү тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийг хөгжүүлнэ. Мөн банкны ажилтан, харилцагч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч түнш болон бусад оролцогч талуудын итгэлцлийг нэмэгдүүлэн харилцаа холбоог өргөн хүрээнд бэхжүүлнэ.

Төрийн банк "Нэгдсэн Үндэсний Байгууллагын Даян дэлхийн гэрээ" / UN Global Compact/-нд 2023 оны тавдугаар сард нэгдсэн.



"Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл"-д Төрийн банк 2023 оны зургаадугаар сард гишүүнээр элссэн.



Partnership for Carbon Accounting Financials (PCAF) буюу Бүртгэлийн санхүүгийн түншлэл нь зээл, хөрөнгө оруулалттай холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг үнэлж, ил тод болгох нэгдсэн арга барилыг боловсруулж хэрэгжүүлэхээр хамтран ажилладаг дэлхийн хэмжээний түншлэлийн байгууллага билээ. PCAF нь 2015 оноос эхлэн ил тод хариуцлагатай байдлыг бий болгож санхүүгийн байгууллагуудад зориулан хүлэмжийн хийн нягтлан бодох бүртгэлийн дэлхийн хэмжээний нэгдсэн стандартыг боловсруулсан глобал түншлэл юм.

Төрийн банк нь Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтынхоо хүрээнд Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэлд (PCAF) Монгол Улсаас 5 дахь гишүүн болж элсэн орсон бөгөөд зээл, санхүүжилтдээ хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын аргачлалын дагуу тооцож, тайлагнахаар зорин ажиллаж байна. Ингэснээр оролцогч талуудад ил тод байдлыг бий болгох, уур амьсгалтай холбоотой шилжилтийн эрсдэлийг удирдах, уур амьсгалд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх болон санхүүгийн урсгалыг Парисын хэлэлцээртэй уялдуулах чухал ач холбогдолтой юм.



PCAF нь 2023 оны эцсээр дэлхийн өнцөг булан бүрээс нийт 60 гаруй орны 450 гаруй санхүүгийн байгууллагууд гишүүнээр элсэн, үйл ажиллагаа нь тэлсэн байна.



Иргэдийн аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд Төрийн банк хувь нэмрээ оруулах зорилгоор Монголын Хог Хаягдлыг

Дахин Боловсруулах Үндэсний Холбоотой хамтын ажиллагааг эхлүүлэн гишүүн байгууллагаар элсэн орлоо. Хамтын ажиллагааны хүрээнд хог хаягдлыг ангилахтай холбоотой сургалтад Төрийн банкны 47 ажилтан хамрагдаж, банкны төв байрнуудын давхарт бүрт хог ангилах боломжтой сав байршуулан хогоо дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэж эхэллээ. Мөн холбооны гишүүн, дахивар нөөц авах цэгийн 37 бизнес эрхлэгч нарт өрхийн зээл, гарааны бизнесийн зээлээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, Инкубатор төвийн сургалтанд хамруулав.



Бид 2013 оноос Монголын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэж, 2018 оноос Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбооны гишүүн байгууллагаар элсэж, банкандаа ТоС-ийн ажлын хэсгийг байгуулсан юм. Үүнээс хойш холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн бөгөөд ТоС холбооны дэргэдэх БОНЗ, уур амьсгалын эрсдэлийн мэргэжлийн зөвлөл, Ногоон зээлийн бодлого, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мэргэжлийн зөвлөлд тус тус гишүүд болон даргаар идэвхтэй хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн замын зургийн зорилтуудтай уялдуулан бид Ногоон зээл, Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан зээл, санхүүжилтийн зорилтот багцыг 2030 он гэхэд 10 хувьд хүргэнэ.





ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА



“Тэрбум мод”  
үндэсний  
хөдөлгөөнийг  
дэмжих “Тэрбум  
мод сан”-д

шимтгэлийн  
орлогоос

**1,204.8**  
**сая төгрөг**  
хуримтлуулсан

“Тэрбум мод сан”-  
гаас нийт 34 төслийг  
сонгон шалгаруулж  
санхүүжилт олгосон  
бөгөөд санд  
төлөвлөрүүлсэн  
санхүүжилтээс Төрийн  
банканд хамаарах  
хэсгийг хувьчилж  
тооцвол



**6,075 м.кв** ногоон байгууламж,  
**16,800** мод,  
**11.24 га** талбайд ойжуулалт,  
**21** шинэ ажлын байр,  
**1 шинэ технологи** ойн салбарт  
туршиж байна.

ШИНЭЧИЛГЭЭ

### Шинэчилгээ нэвтрүүлэг

Гэр хороололд гал түлэхгүй, утаагүй, урсгал зардалгүй, дулаахан тухтай амьдрах боломжийг олгосон технологийн шийдлийг илүү сонирхолтой шинэлэг хэлбэрээр иргэдэд таниулах зорилгоор



“Шинчилгээ” цуврал төсөл нэвтрүүлгийг МООД болон Хайбрид хаус ХХК-тай хамтран “Монгол ТВ” телевизийн эфирээр болон социал сувгаар дамжуулан давхардсан тоогоор

• **6.5 сая үзэгчид хүргэлээ.**



ДУЛААН ШИЙДЭЛ  
SWITCH OFF AIR POLLUTION

### Дулаан Шийдэл 2 төсөл

Европын Холбооны Свич Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан Шийдэл 2” төслийн хүрээнд Жерес Олон Улсын төрийн бус байгууллага болон Монголын ногоон санхүүгийн корпорацитай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.



Уг төсөл нь хувийн сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой.

## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн банк нь БНХАУ, Япон, ХБНГУ, ОХУ, БНСУ, Сингапур зэрэг 6 орны нөлөө бүхий 15 банктай корреспондент харилцаатай бөгөөд худалдааны санхүүжилтийн зээлийн шугамаар Тайванийн EXIM банк, олон улсын Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйлчилгээгээр Euroclear банктай, олон улсын зах зээл дээр гадаад валют, үнэт цаас, хувьцаа, үнэт металлын арилжаанд зуучлах брокерын үйлчилгээгээр Saxo банктай тус тус хамтран ажилладаг.



Moody's байгууллагаар Зээлжих зэрэглэлийн нөлөөллийн оноо (ESG Credit Impact Score)-г тооцуулж, CIS-2 Сөрөг нөлөөлөл бага (Neutral-to-Low) үнэлгээ авлаа.





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

---



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн банкны Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах Тогтвортой хөгжлийн журмыг шинэчлэн баталлаа. Түүнчлэн “Тогтвортой хөгжлийн хороо”-ны үйл ажиллагааны журмыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хорооны бүрэлдэхүүнийг томилов.

Банкны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд “Тогтвортой хөгжлийн алба”-г шинээр байгуулж, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг банкны бүхий л түвшинд хэрэгжүүлэх зорилго бүхий Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, чиглэл тус бүрт анхааран ажиллаж байна.

 **Тогтвортой хөгжлийн хороо**

 **Тогтвортой хөгжлийн журам**

 **Тогтвортой хөгжлийн алба**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Тогтвортой санхүүгийн долоо хоног-2023” цуврал арга хэмжээ зургаадугаар сарын 13-16-ны өдрүүдэд болж, олон улсын манлайллын хөтөлбөр, өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг бүхий тус арга хэмжээнд Төрийн банк “Тогтвортой хөдөө аж ахуйг санхүүжүүлэх нь” сэдэвт салбарын хуралдааныг ТоС холбоотой хамтран амжилттай зохион байгууллаа.



Монгол Улсад банкны салбар үүсгэн байгуулагдсаны 99 жилийн ойн хүрээнд “Санхүү банкны эмэгтэйчүүд хоёрдугаар чуулган”-д Төрийн банкны 60 гаруй эмэгтэй удирдагч болон манлайлагч ажилтнууд оролцлоо.



Бизнес төлөвлөгөөний дагуу Тогтвортой хөгжлийн чиглэлээрх зөвлөх үйлчилгээ болон Банкны хүлэмжийн хийг тоолох 2 зөвлөх үйлчилгээний хүрээнд тендерт шалгарсан байгууллагуудтай гэрээ байгууллаа. Энэ нь Тогтвортой хөгжлийн чиглэлээр урт хугацааны стратеги боловсруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Банкны хүлэмжийн хийн ялгарлын тооллогыг хийлгэх зөвлөх үйлчилгээний хувьд Банкны төв


болон салбар, нэгжийн үйл ажиллагааны хүрээнд Score 1 ба 2 хүлэмжийн хийг тоолох, шаардлагатай дата мэдээллийг цуглуулах, Олон улсын хүлэмжийн хийн тооллогын стандарт (GHG Protocol)-ын дагуу байгууллагын хүлэмжийн хийн шууд ялгарлыг тооцоолуулж тайлан боловсруулснаар цаашид банк өөрийн хүлэмжийн хийг хэрхэн бууруулах төлөвлөгөөг гарган ажиллах давуу талтай юм.





### Гялс цэвэрлэгээ аян:

Байгаль орчноо хамгаалах үйлсэд байгууллага, олон нийтийг уриалан дуудаж нийгэмд эерэг хандлага түгээхээр энэхүү аяныг зургаа дахь жилдээ зохион байгууллаа.



21 аймаг, 315 сумын гол горхи, ундны усны сав газар, Улаанбаатар хотын Туул гол, Сэлбэ голын сав газар орчмын нийт

- 21,500 гаруй га газрыг цэвэрлэж
- 2800 гаруй тонн,
- 1600 орчим автомашин хог хаягдлыг цуглуулж хаялаа.



Банкны ажилтнуудыг тогтвортой хөгжлийн чиглэлээр чадавхжуулах зорилгоор тогтвортой хөгжлийн талаар ерөнхий мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж, 1809 ажилтанд 16796 цагийн сургалт орлоо.



**1809**  
ажилтанд



**16796**  
цагийн сургалт орлоо.

Мөн энэ чиглэлээр гаднын байгууллагаас хүний эрхийн магадлал шинжилгээ, дохионы хэлний сургалт хэрэгжүүлж, банкны ажилтнууд амжилттай хамрагдлаа.



Банк **500 гаруй салбар нэгжээр дамжуулан** цахим үйлчилгээг харилцагчдад түлхүү ашиглахыг санал болгож байна.



Цаасан маягтыг  
**12%-иар**



принтер, хувилагчийн хорны зардлыг  
**10%-иар**



тус тус бууруулж ажиллав.

Төрийн банк нь "МОДЫГ МОД(А) БОЛГОЁ-АЖИЛТАН БҮР НЭГ МОД" аяныг 2018 оноос хойш зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2030 он гэхэд 100,000 мод тарих зорилт тавьсан билээ.



**4000**  
гаруй ажилтан



○ 34 нэр төрлийн  
○ 6,586 ширхэг  
мод тарьялаа



## ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР



Чиг үүрэг, орон тоог зохистой хуваарилах замаар 2023 онд **49** ажлын байрыг шилжүүлэх болон шинээр нэмэгдүүлсэн.



Ур чадвартай ажилтныг нээн илрүүлж, ажилтнуудын карьер хөгжлийг дэмжиж, тасралтгүй сургаж хөгжүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.



Ажилтнуудыг чадваржуулах, хөгжүүлэх, зайнаас суралцах боломжийг бий болгож, нэгжийн ажилтнуудад чиглэсэн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, танхим, онлайн, цахим хэлбэрийн нийт **173** удаагийн сургалт зохион байгуулснаас нийт ажилтны **92** хувь цахим сургалтад хамрагджээ.



Банкны залгамж халаа болох ур чадвартай ажилтныг нээн илрүүлэх зорилго бүхий **"Талант менежмент 2023"** ур чадварын уралдааныг 3 дахь жилдээ зохион байгуулж, ур чадвартай ажилтны нөөц санг нэмэгдүүллээ.



Ажилтнуудыг мэргэшил дээшлүүлэх, мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж **18** ажилтанд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүллээ.



Их, дээд сургуулийн оюутан залууст практикт суурилсан ажлын бодит туршлага хуримтлуулах, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломжийг олгож СЭЗИС, ОТИС, ХААИС, ИЗОУИС-тай ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн **35** оюутныг цалинтай дадлагажуулж "Ажлын байрны батламж" урилга гардууллаа.



Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудыг идэвхжүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.



Банкны төв оффисын ажилтнуудыг идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор газар, хэлтэс, албадын дунд **"Манлайлагч хамт олон"** уралдааныг зохион байгуулж, шалгарсан хамт олныг урамшууллаа.



Ажилтнуудын сайн дурын сонирхлыг дэмжсэн SB клубыг байгуулж, "Банкир соёл-Эерэг хандлага түгээх хөтөлбөр II"-ийг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эерэг хандлагын тухай **26** видео, подкаст, контентуудыг цувралаар бэлтгэн нийт ажилтанд түгээж, **31** видео хичээл болон гарын авлагыг боловсруулан сургалтын нэгдсэн программд байршуулсан.



Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор **200** ажилтанд орон сууцны зээлийн эрх олголоо.



Банкны төв оффисын ажилтнуудад ажлын уян хатан цагийн горим нэвтрүүлж, зайнаас ажиллах боломжийг олгож байна.



Хүүхэд асрах чөлөө авсан ажилтанд богиносгосон цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажлын уян хатан цагийн хуваариар өөрийн сонгосон цагаар ажиллах боломжийг олгов.



Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрууллаа.

## Дотоодын сургалтын хүрээнд



Төрийн банкны Бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд “Өртөө консалтинг” ХХК-тай хамтран “Бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоо /БТБМТ/- ISO22301:2019” сэдэвт сургалтыг банкны төвийн удирдлагууд, ажлын хэсгийн гишүүд болон холбогдох газар хэлтсийн мэргэжилтэн зэрэг нийт 60 гаруй ажилтныг хамруулан зохион байгууллаа.

Дундаж давхаргыг дэмжих, олон нийтэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд Монгол банктай хамтран “Сургагч багш бэлтгэх” сургалтыг зохион байгуулж, төвийн газар, хэлтэс, салбар нэгжийн 45 ажилтанд “Сургагч багш” батламж олголоо.



Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлого сэдэвт сургалтыг Монголын Тогтвортой санхүүжилтийн холбоо, НҮБ-ын Хүүхдийг ивээх сантай хамтран амжилттай зохион байгууллаа.



Ажилтнуудаа “Бие хүний сэтгэл зүй ба хөгжил” болон “Ажил амьдралын тэнцвэр” сэдэвт цахим сургалтад хамрууллаа.

Тогтвортой хөгжлийн чиглэлээр Монголын Тогтвортой санхүүжилтийн холбооноос зөвлөх үйлчилгээ авч, банкны удирдах ажилтнуудыг нэгдсэн сургалтад хамруулав.



## Гадаад сургалт, хөтөлбөрийн хүрээнд




Канадын Худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага (CTIF)-тай хамтран ТоС Холбооноос Сингапур улсад зохион байгуулсан туршлага судлах аялалд хамрагдлаа. Тус аяллын хүрээнд ТоС Холбооны гишүүд БОНЗ болон тогтвортой санхүүгийн үйл ажиллагааг олон улсын

жишигт нийцүүлэн явуулж буй үлгэр жишээ институт болон компаниудтай танилцан, түншлэл тогтоож, БОНЗ-той холбоотой шаардлага болон дэлхий даяар хувьсан өөрчлөгдөж буй хөрөнгө оруулалтын механизмыг судалсан тун үр өгөөжтэй аялал боллоо.

Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилттэй “Бэлэн байдлын хөтөлбөр”-ийн хүрээнд Франкфуртын их сургуулийн мэргэшүүлэх сургалтад 1 ажилтан хамрагдаж, “Certified expert in sustainable finance” сертификатаа авлаа.



ТоС Холбоо, Азийн сан байгууллагын санаачилж, Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран анх удаа хэрэгжүүлж буй санхүүгийн салбарын эмэгтэйчүүдийн манлайлын “Women in Finance” хөтөлбөрт Төрийн банкны төлөөлөл оролцов.



## НОГООН ОФФИС



10%

Улаанбаатар, орон нутгийн 496 салбар нэгжээр дамжуулан цахим үйлчилгээг харилцагчдад түлхүү ашиглахыг санал болгосноор өнгөрсөн жилд цаасан маягтын зардлыг 12 хувиар, принтер болон хувилагчийн хорны зардлыг 10 хувиар тус тус бууруулав.

Ногоон худалдан авалтыг дэмжин 2023 онд нэг дор олон үйлдэл



багтаасан, унтрааж, амраах хэмнэлтийн горимтой техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг нэмэгдүүлэв. Түүнчлэн 70 хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс сонгосон байна.



Банкны төв оффисуудад дулааны хэрэглээг хэмнэх зорилгоор гадаа дулаан байгаа үед болон амралтын өдрүүдээр дулааны температурыг тохируулгаар багасган тохируулах, хаалга, цонхнуудын алдалтыг багасгаж байна.



Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоонд гишүүнээр элсэж, хог хаягдлыг ангилах сургалтыг Төрийн банкны ажилтнуудад зориулан хийж, улмаар банкны төв байруудын давхар бүрт хог ангилах сав байршуулж, хогийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэж байна.



Ажилтнуудын ухамсар, хандлага, өдөр тутмын дадлыг хэвшүүлэхээр банкны үйл ажиллагааны зардлуудыг хэмнэх аргуудыг багтаасан мэдээлэл бүхий зурагт хуудсыг бэлтгэн, 7 хоног бүр тогтмол давтамжтайгаар цахим шуудангаар системийн хэмжээнд хүргүүлж байна. Банкны төв оффис болон нийт нэгжийн ажилтнуудад цайны цагаар гэрлээ унтраах, байгалийн гэрэлтүүлэг ашиглах хөдөлгөөнийг өрнүүлэн өдөр тутамд хэвшил болгосноор цахилгааны зардлыг хэмнэж байна.



Төрийн банк нийгмийн хариуцлагын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтыг хэрэгжүүлэхээр ногоон хөгжлийн бодлогыг үйл ажиллагаандаа хэвшүүлж, байгаль орчныг хамгаалахад ажилтан бүрийн оролцоо, идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, салбар нэгжийн ашиглалтын зардлыг бууруулах зорилгоор “НОГООН ХӨГЖИЛ” аяныг зарлаж хэрэгжүүлсэн.

## ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Миний Монгол-2023” үзэсгэлэн худалдааг өөрийн харилцагч, жижиг дунд үйлдвэр эрхлэгч нарыг олон нийтэд сурталчлан таниулах, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлж, банкны цогц үйлчилгээг олон нийтэд хүргэх зорилгоор амжилттай зохион байгууллаа.



Байгаль эхээ хамгаалах, хойч үеэ байгальд хайртай иргэн болгох зорилгоор “Хүрээлэн” төсөлтэй хамтран 2020 онд “Эко карт”-ыг зах зээлд нэвтрүүлсэн. 2023 онд 23,051 ширхэг Эко карт борлуулж, 23.0 сая төгрөгийг ховор амьтдыг хамгаалах үйлсэд зориулав.



“Хүндэтгэлийн аян-2023”-ыг сар шинийн баярыг тохиолдуулан зохион байгуулж, өндөр настай харилцагч нартаа хүндэтгэл үзүүлээ.



“Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ - 2023” аяныг нийт ажилтнуудын дунд Монгол орон даяар 21 аймгийн 315 суманд зохион байгуулж 7,400 гаруй га талбайг цэвэрлэж, 800 тонн буюу нийт 400 гаруй автомашин хог хаягдлыг цэвэрлэв.



Банкны шигшээ багийн тамирчдыг “Улаанбаатар марафон-2023” оролцох уриалгыг гаргаж нийт 18 ажилтан манлайлан хамтдаа марафонд оролцов.



“ABILITY EXPO 2023” арга хэмжээнд Төрийн банк хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд эергээр сурталчлан таниулах, тэдгээр иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдэнд санхүүгийн боловсрол олгон, хүртээмжтэйгээр санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг хүргэж оролцлоо.



Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран Цаг агаарын болзошгүй аюул, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх 40 удаагийн мэдэгдлийг “Гялсбанк аппликейшн”-аар дамжуулан давхардсан тоогоор 972,556 харилцагчид хүргүүлээ.





*Байгальд  
ээлтэй*  
**ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ  
2024**  
*аян*

## Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд

Банкны Инкубатор төв болон хамтран ажиллагч байгууллагуудаар дамжуулан бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа, санхүүгээ амжилттай удирдахад хэрэгцээт мэдлэг олгох, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 6,453 бизнес эрхлэгчид сургалт зохион байгууллаа.

Банкнаас олон нийтийг хамарсан арга хэмжээг тохиолдуулан болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сувгаар дамжуулан 609,100 иргэнд санхүүгийн боловсрол олгох мэдээ, мэдээллийг хүргэж ажиллалаа.

Бидний ирээдүй болсон хүүхэд багачууд, залуусын санхүүгийн боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, ирээдүйн банкны харилцагч дундаж давхаргын иргэдийг бэлтгэх, хуримтлал бий болгох дадал зуршилд суралцуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн сурагч, оюутнуудад зориулсан “Санхүүч тагтаа” хөтөлбөрийг боловсруулж, Улаанбаатар орон нутгийн бүх салбар, тооцооны төвүүдээр дамжуулан хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд нийт 42,825 оюутан, сурагчдад сургалт зохион байгууллаа.

Олон нийтэд санхүүгийн боловсрол түгээх, хуримтлалын ач тус, мөнгөө хэрхэн зөв зарцуулах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх 10 цуврал контентыг Монголбанкны эдийн засагчид, Германы Шпаркассэ банк болон олны танил санхүүгийн экспертүүдийг оролцуулан бэлтгэж, Төрийн банкны вэб сайт болон бусад сошиал сувгуудаар шат дараатай байршуулах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Тус контентод “Даатгал”, “Санхүүгээ хэрхэн удирдах вэ”, “Хуримтлал”, “Орлого зарлагаа хэрхэн удирдах вэ”, “Зээл хэрэгтэй юу?”, “Залуу гэр бүлийн санхүү” зэрэг сэдвүүд багтсан.

## Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх



**Брэнд реклам**  
2.3 сая иргэнд мэдээлэл хүргэлээ



**25 цуврал видео контент**  
Бизнес эрхлэгчдийг оролцуулсан “Амжилтын түүх” 25 цуврал контентийг сошиал сувгаар 147,411 иргэнд хүргэсэн.



**“Харилцагчийн өдөрлөг-2023” арга хэмжээ**



Улаанбаатар - 2 дүүрэг  
Орон нутаг-10 аймаг



**18,436**  
Бизнес эрхлэгч  
Инкубатор төвийн харилцагч болж Санхүүгийн боловсрол олгосон.



**132,294**  
Оюутан, сурагч



Нийт **2,539,155** иргэнд  
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

### Сургалт

- Бизнесийг удирдах арга
- Манлайлагчийн ур чадвар
- Брэндиг болон маркетинг
- Орлого зардлын бүртгэл
- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Эрсдэлийн удирдлага
- Санхүүгийн удирдлага



Олгосон зээл  
**404** харилцагч  
**17.4** тэрбум төгрөг



Хамтын ажиллагаа **6** байгууллага  
ЖДҮТ, МУХАУТ, Баст хөтөлбөр, СЭЗИС,  
Гослингсо ментор клуб, Эрүүл амьдралын жигүүр ТББ




# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

---

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Төрийн банк нь Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд олон улсын санхүүгийн байгууллага, дотоодын яамд болон ногоон, байгальд ээлтэй төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тайлант хугацаанд ногоон таксономийн ангиллаар ногоон зээлийн багц бүрдүүлж ажилласан бөгөөд 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувьд хүргэхээр ажиллаж байна.



Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүний багцыг нэмэгдүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүн”-ийн нөхцөлийг сайжруулан төрөлжүүлж зах зээлд нэвтрүүллээ. Ингэснээр харилцагч эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, хайбрид болон байгалийн хийн хөдөлгүүрт автомашин, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц засварлах зэрэг зээлийг хөнгөлттэй, уян хатан нөхцөлөөр авах боломжтой болсон бөгөөд энэ чиглэлийн багц өмнөх оноос 5.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Эко тээврийн хэрэгслийн төрлийг хайбрид болон байгалийн хийн хөдөлгүүрт автомашин болгон ангилж, ангиллаас хамаарч зээлийн хүүг шатлалтай тогтоолоо.



Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, худалдан авах зээлийн хувьд банк хамгийн анх ToC холбоо болон GIZ төслийн байгууллагатай хамтран урьдчилгаа төлбөрийн татаас бүхий анхны туршилтын төслийг хэрэгжүүлж байсан бөгөөд өөрийн эх үүсвэрийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, эрчим хүчний хэмнэлтийн хувиас хамаарсан зээлийн хүүгийн хувийг нэвтрүүлсэн.



Ахуйн хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа худалдан авах зээл, Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах зээл болон Агаар, хөрсний бохирдол бууруулах ногоон зээлийн бүтээгдэхүүнийг тус тус шинэчлэн зах зээлд нэвтрүүллээ.

## ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ НОГООН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД



Япон улсын Засгийн газар болон Монгол Улсын Сангийн Яамтай хамтарсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл” буюу JICA төслийн зээлийг байгаль орчныг хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэсэн хоёр үе шаттайгаар олгодог. Энэхүү төсөл нь техник технологийн болон арилжаа, санхүүгийн хувьд найдвартай байх, эрүүл ахуй, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны болон удирдлагын стандартад нийцсэн байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих 78 төслийн 38.1 тэрбум төгрөгийн зээл, байгаль орчныг хамгаалах 11 төслийн 5.9 тэрбум төгрөгийн зээл, нийт 89 төслийн 44.0 тэрбум төгрөгийн зээлийг 2006 оноос хойш санхүүжүүлээд байна.



**БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Жилийн 9-13 хувийн хүүний татаастай “Байгальд ээлтэй хүүний хөнгөлөлттэй төсөл”-ийг БОАЖЯ (Байгаль орчин, аялал жуулчлалын яам) – тай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төслийн гол зорилго нь агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж, хүлэмж, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах, мод бут, ногоон байгууламж байгуулах, цахилгаан тээврийн хэрэгсэл худалдан авах, хийн халаалтын төхөөрөмж худалдан авах, суурилуулах, ногоон амины орон сууц худалдан авах, бариулах зэрэг зориулалтаар олгодог. “Байгальд ээлтэй хүүний хөнгөлөлттэй төсөл”-ийн хүрээнд 331 зээлдэгчид 5.0 тэрбум төгрөгийн зээлийг 2020 оноос хойш хугацаанд олгосон байна.



**БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх” төслийн хүрээнд Тусгай хамгаалалттай бүс нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээлийг Завхан, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймагт, Германы KfW байгууллагын санхүүжилтээр бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх буюу “Малын тоо толгойг нэмэгдүүлэхгүй байх” зорилго бүхий зээлийг Хэнтий, Дорнод, Архангай, Хөвсгөл аймагт тус тус харилцагчид санал болгож байна. Төслийн хүрээнд нийт 610 зээлдэгчид 5.1 тэрбум төгрөгийн зээлийг олгов.



ТоС Холбооноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБ Хүүхдийн сан)-тай хамтран эрчим хүчний хэмнэлттэй Монгол гэрийн дулаалга, халаалтын CHIP багцыг зорилтот бүлэгт өгөх хөнгөлөлттэй ногоон зээлийг хэрэгжүүлэхэд Төрийн банк хамтран ажиллаж байна.



## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

### Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл



Төрийн банк 2019 онд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг зах зээлд нэвтрүүлсэн нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн дунд хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болж чадсан бөгөөд 2023 онд 1,878 зээлдэгчид 77.5 тэрбум төгрөгийн зээлийг олгож, тэдний бизнесийн үйл ажиллагааг бодитоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, бизнесийн цар хүрээг нь тэлжээ.

### Боловсролыг дэмжих зээл



Дундаж давхаргыг дэмжигч банкны цогц үйлчилгээг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Сургалтын төлбөрийн зээл”-ийн бүтээгдэхүүнийг туршилтын хугацаанд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2023 оны хоёрдугаар сараас тус бүтээгдэхүүнийг “Боловсролыг дэмжих зээл” нэршлээр шинэчлэн нөхцөл, шаардлагыг сайжруулж зээлийн хэмжээ, хугацааг

нэмэгдүүлсэн. Тус зээлийг сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй иргэнд сургалтын төлбөрөө төлөх, дотуур байрны төлбөрөө төлөх, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад нь зориулж олгодог бөгөөд 25 зээлдэгчийн 0.22 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

### Өрхийн бизнесийн зээл



Дундаж давхаргын иргэдийг дэмжих зорилгоор тодорхой хугацаанд бичил бизнес буюу жижиглэнгийн худалдаа, өрхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн Улаанбаатар хотын болон орон нутгийн иргэдийг Банкны бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулж, санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх замаар бизнесээ амжилттай

удирдахад нь тодорхой хэмжээнд тусалсны үндсэн дээр өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зориулан Өрхийн бизнесийн зээлийг шинээр нэвтрүүлж 282 зээлдэгчид 7.5 тэрбум төгрөгийн зээлийн багц бүрдүүлээ.

### Гарааны бизнесийн зээл



Дундаж давхаргыг дэмжих зорилгоор бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд болон гарааны бизнес эхлүүлэхээр зорьж буй иргэн, аж ахуйн нэгжийг Банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулан гарааны бизнесийн зээлийг

шинээр олгож эхэллээ. Тухайлбал, Улаанбаатар хотын болон орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг Банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан бизнесийн болон санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх, үйл ажиллагааны эхлэлийн болон өсөлтийн мөчлөгөөс тогтворжих түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэн, технологийн шинэчлэлт хийх, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө бэлтгэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан уг зээлийг олгож байна. Энэ хүрээнд 116 зээлдэгч 8.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



Төрийн Банкны “Эко боловсрол олгох аян”-ы хүрээнд Хүрээлэн төсөлтэй хамтран нэн ховор амьтдын зурагтай ЭКО картыг 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд нийт 96,727 картын борлуулалтын хураамжаас 1000 төгрөгийг нэн ховордсон амьтдыг хамгаалах санд шилжүүлж байгаль, ан амьтдаа хамгаалахад хувь нэмэр оруулав.



Бид 2022 онд Юнионпэй карт гаргагч байгууллагын Travel Mate Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой, аяллын “Save green” кредит картыг зах зээлд нэвтрүүлж, нийт 353 ш карт олгоод байна.



Банк 21 аймгийн үзэсгэлэнт байгалийн зурагтай “Миний Монгол” олон улсын виза карт 2021 оноос харилцагчдадаа санал болгож эхэлсэн бөгөөд нийт 13,850 карт олгоод байна. Тус картын хураамжийн орлогоос 7,656,000 төгрөгийг тухайн аймгийн байгаль хамгаалах санд зориулан хуримтлуулж байна.



Төрийн банк “Дундаж давхаргыг дэмжигч, Үндэсний тэргүүлэгч банк” байх зорилтын хүрээнд “Эрүүл амьдралын жигүүр” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2022 онд байгуулсан. Дундаж давхаргын иргэдэд хуримтлалын зуршил бий болгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд гадаад, дотоодын гэрээт эмнэлгүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах боломжийг олгосон “Эрүүл иргэн” хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн, “Эрүүл иргэн” олон улсын виза картыг тус тус зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2023 оны эцсийн байдлаар 8,358 хадгаламж, 2,170 карт шинээр нээгдсэн байна

## СУРГАЛТ



Тогтвортой хөгжлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч, энэ хүрээнд харилцааны менежерүүд болон бусад холбогдох ажилтнуудад “Ногоон зээлийн хөгжүүлэлт” сэдэвт сургалтыг олон улсын зөвлөхүүдээс авлаа.



“Хүлэмжийн хийн ялгарлыг тоолох” зөвлөх үйлчилгээг авч, мэргэжлийн байгууллагын сургалтуудад Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн гишүүд хамрагдлаа.



Улаанбаатарын салбар нэгжийн харилцааны менежерүүдэд тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний воркшоп чадваржуулах сургалтыг амжилттай зохион байгууллаа.

## САЙН ТУРШЛАГА



Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд оролцогч талуудын уялдааг бий болгох, технологи хөгжүүлэгч талын хөгжүүлэлт дээр манай банк хамтран ажиллаж байна. Тухайлбал:

### - ХАЙБРИД ХАУС ХХК



Нийлүүлэлтийн сүлжээг турших зорилттой нийцүүлэн Хайбрид хаус ХХК-тай зээлийн санхүүжилтээр хамтран ажиллалаа. Энэ хүрээнд Хайбрид хаус ХХК болон НОСК-тай хамтран ногоон орон сууцны хамгийн оновчтой технологиудыг эрэлхийлж “Эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууц”-ыг 2 байршилд нийт 16 айлын орон сууцны туршилтын төслийг амжилттай дуусгалаа.

Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуурын эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэж 2023 -2024 оны өвлийн улиралд 1247 өрхийг утаагүй технологид шилжүүллээ.

### - ЭКО НООС ХХК



Монгол хонины ноосыг дахин боловсруулах үйлдвэрлэл дутмаг байгаагаас хог хаягдал болж буй хонины ноосыг эко барилгын бүтээгдэхүүн болгох, эцсийн хэрэглээнд хүргэх зорилттой “Эко ноос” ХХК хонины ноосыг барилгын түүхий эд материал болгон экспортолж байна. Монгол улсад нэн шаардлагатай барилгын түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгож, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон амины орон сууц барилгад ашиглах загвар төслийг Төрийн банк тус компанитай хамтран хэрэгжүүлж, 2023 онд туршлаа.

“Эко ноос” ХХК модон арагт, дулааны алдагдал багатай Канад модон барилгын технологи дээр экологийн цэвэр бүтээгдэхүүн болох Монгол хонины ноосон барилгын дулаалгын материалыг ашиглаж дулаан алдагдал багатай, эрчим хүчний 61%-ийн хэмнэлттэй ногоон барилгыг орон нутагт нутагшуулж байгаа юм.



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Төрийн банк нь бизнесийн болон төслийн зээлийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийг харгалзан үздэг. Уг эрсдэлийг удирдах боломжтой гэж үзсэн тохиолдолд зээл олгох, төслийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Банк байгаль орчны чиглэлээр мэргэшсэн үнэлгээчинтэй болсон бөгөөд БОНЗЭҮ-ний аргачлалыг Олон улсын санхүүгийн корпорацаас тодорхойлсон эрсдэлийн төрлүүдтэй уялдуулж, Дэлхийн банкны үнэлгээний аргачлалтай нийцүүлэн үнэлгээг хийж байна.

Банкны хэмжээнд байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй байж болзошгүй, 100 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш урт хугацаатай бүх бизнесийн зээлийн хүсэлтэд БОНЗЭҮ хийж байна. БОНЗЭҮ бүхий мэдээллийн баазтай болох, улмаар эрсдэлийг мэдээлэх, тайлагнах, хянах боломжийг бүрдүүлэх зорилгоор үнэлгээг системийн хэмжээнд нэвтрүүлсэн. Зээлийн бодлогоор хориглох үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд санхүүжилт өгөхгүй, анхаарах үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэж байна.

БОНЗЭҮ-ээр өндөр болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн зээлүүдэд эрсдэл бууруулах зөвлөмж өгч, үүргээ хэрэгжүүлж буй эсэхэд зайнаас болон газар дээрх хяналтыг гүйцэтгэдэг.

### БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ:

- Бизнесийн зориулалттай

12 сараас дээш


100 сая ₮-с дээш дүнтэй

2023  
ОНД

215 зээлдэгчийн

63.8 тэрбум төгрөг

### БОНЗЭҮ хийгдсэн зээл олголтын эдийн засгийн ангиллаар



## ТАЙЛАГНАЛ



Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөлөөс ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын шалгуур үзүүлэлт бүхий “Ногоон таксономи”-г 2019 онд баталсан бөгөөд банк тус 8 ангиллын дагуу олгосон ногоон зээлийн олголт, төлөлт, үлдэгдлийн мэдээг улирал бүр Монголбанканд тогтмол тайлагнаж байна.



Бид Тогтвортой санхүүжилтийн холбоонд хагас жил бүр сайн дурын үндсэн дээр Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу хийгдсэн ажлын тайлангаа тогтмол тайлагнаж байна. Уг тайлангаар Тогтвортой санхүүжилтийн менежментийн систем, Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем, зээлийн байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, ногоон зээл олгосон байдал болон ToC-ийн 8 зарчмын дагуу хийгдсэн ажлуудын хэрэгжилтийн мэдээллийг тайлагнадаг.



Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор Байгаль орчин, нийгэм засаглалын 2023 оны тайланг зохицуулагч байгууллагуудаас гаргасан удирдамжийн дагуу Монголын Хөрөнгийн биржид хүргүүлдэг.



Банкны Тогтвортой хөгжлийн жилийн тайланг анх удаа бэлтгэн олон нийтэд хүргэлээ.





☎ 1800-1881

🌐 [www.statebank.mn](http://www.statebank.mn)

📘 /StatebankMN



АВИЛГАТАЙ  
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД

☎ 110 Гомдол мэдээлэл  
хүлээн авах утас